



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22-өдөр

Дугаар 465

Улаанбаатар хот

Төрийн өмчид хөрөнгө хүлээн авч,
буулгах, шилжүүлэн барих зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.3, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн мэдэлд хувийн өмчөөс шилжүүлэн өгсөн 217,062,083.00 (хоёр зуун арван долоон сая жаран хоёр мянга наян гурван) төгрөгийн үнэ бүхий ХТП-5885 дугаартай дэд өртөөг төрийн өмчид хүлээн авч Буянт-Ухаа спорт ордоны засвар үйлчилгээний төслийн хүрээнд газар чөлөөлөх зорилгоор буулгаж, шилжүүлэн барихыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан, “Буянт-Ухаа спортын ордон” ТӨҮГ-ын захирал Л.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор дэд өртөөний барилгыг буулгаж, зөөн шилжүүлэх, ашиглаж буй тоноглолуудыг хүлээн авах, шинээр барих дэд өртөөний барилга болон шинэ тоноглолуудыг үндсэн хөрөнгөд бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

000906